

Керамик хавтан болон керамик боржин (керамогранит) хавтангийн цавуу PLITONIT PLITOMAX (B+)



25 кг	Цавууны ангилал: C2 TE
5 кг	<ul style="list-style-type: none"> ✓ Нээлтэй байх хугацаа (ажиллах хугацаа) – 30 минут ✓ Ажил гүйцэтгэхэд илүү эвтэйхэн ✓ Усан санд санал болгодог ✓ «Шалны халаалтын» системд тохиромжтой



МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН

Дотор заслын хавтангийн хамгийн том хэмжээ

Гадна заслын хавтангийн хамгийн том хэмжээ

1200 x 900 мм

Зааврыг өөр хэлээр татах/
Download the manual in another language
kz | az | uz | tj | kg | tm | am | ge | mn

Хэрэглээний хүрээ

Түрхлэгийн төрлүүд	Шал	Ханын гадаргуу
Керамогранит	+	+
Керамик хавтан	+	+
Шатаасан шавар хавтан	+	+
Байгалийн ба хиймэл чулуу	+	+
Шигтгэмэл (мозайк) болон тунгалаг хавтан	—	—
Суурь гадаргуугийн төрлүүд	Шал	Ханын гадаргуу
Хэв гажилтад ордоггүй суурь: Бетон, төмөр бетон, хөөсөнцөр (хийт) блок, тоосго, цементэн өнгөлөгч шавардлага болон бусад төрлийн хэв гажилтад ордоггүй сууриуд	+	+
Өөрөө тэгшлэгч шал (холимог болон цементэн суурьтай)	+	—
Бүтэц болон температурын хэв гажилтад ордог (өөрчлөгддөг) суурь	—	—
Гипсэн хавтан, Шилэн судалтай гипсэн хавтан, Шилэн магнетит хавтан	+	+
Нийлмэл: Цементэн зоргодсон хавтан, Зоргодсон (OSB) хавтан	—	—
Нэн хүндрэлтэй суурь: «Хавтан дээр хавтан наах», шүлтэд тэсвэртэй хуучин будгаар будагдсан гадаргуу	—	—
Гипсэн өнгөлөгч шавардлага	+	+
Хэрэглэх хүрээ	Шал	Ханын гадаргуу
Хэвийн чийгшил бүхий өрөө тасалгаа	+	+
Өндөр чийгшил бүхий өрөө тасалгаа	+	+
Гадна талын ажил (нүүрэн тал, суурь гэх мэт)	+	+
Усан бассейн	+	+
Шалны халаалтын системтэй (усан болон цахилгаан) нийцэх чадвар*	+	+

* Хавтан наах болон «дулаан шал»-ны системийг хамтад нь угсрах технологийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг plitonit.ru вэбсайтаас авах боломжтой.

Техникийн үзүүлэлтүүд

Хамгийн том дүүргэгч ширхгийн хэмжээ	0,63 мм
Цавууны үеийн хамгийн их залгааны зузаан	15 мм
Хэрэглэх усны хэмжээ	
• 1 кг хольцод	0,19 - 0,26 л**
• 25 кг хольцод	4,75 - 6,5 л
Хуулралтад тэсвэртэй барьцалдах чадвар, ихгүй	0,5 мм
Хүрэлцэх талбайн ил задгай байх хугацаа, мин	30 минут хүртэл
Хавтанг засах, тохируулах хугацаа, багагүй	30 минут
Зуурмаг хольцын амьдрах чадвар	4 цаг
Дээгүүр нь явж болох чигжээс хийх хугацаа, дараа	24 цаг
Ашиглалтын үеийн температурын горим	-50°C-аас +70°C хүртэл
Хүйтэнд тэсвэртэй байдлын зуурмагийн марк, багагүй	F150
Хуурай агаарт 28 хоногийн турш байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал.	≥ 1,4 МПа
Усан орчинд байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал	≥ 1,0 МПа
Олон удаагийн хөлдөлт, гэсгээлгийн дараах цавууны барьцалдах (наалдах) бат бөх чанар	≥ 1,0 МПа
Өндөр температурт байлгасны дараа цавууны барьцалдах (наалдах) бат бөх чанар	≥ 1,0 МПа

** Шалны наалтад зөвшөөрөгдөх хамгийн их усны хэмжээгээр, хананы наалтад усны дундаж хэмжээгээр найруулж хэрэглэхийг зөвлөж байна.

Гадаргууг бэлтгэх

1	Суурь гадаргууг бохирдол, тоос, тос, өөх тос болон ховхорч буй хэсгүүдээс цэвэрлэнэ үү.
2	Ажил гүйцэтгэхийн өмнө шаардлагатай бол суурь гадаргууг PLITONIT хөрсжүүлэгчээр (грунтовка) боловсруулах шаардлагатай (хөрсжүүлэгч сонгох хүснэгтийг доор харуулав)

Суурь нь СП 71.13330.2017 дүрмийн шаардлагад нийцсэн, хангалттай даацын чадвартай байх ёстой
Гипсэн хавтан, Шилэн судалтай гипсэн хавтан, Шилэн магнетит хавтан зэрэг хавтангаар хийгдсэн каркас (араг) бүтцийн хэв гажилтад ордог сууриуд (хайрцаг, хамар хана гэх мэт) нь өндөр хөшүүн чанартай байх бөгөөд СП 163.1325800.20 дүрмийн шаардлагыг хангасан байх ёстой

Халдаг шалны системтэй суурин дээр ажил гүйцэтгэх тохиолдолд ажил эхлэхээс 2 хоногийн өмнө шалны халаалтын системийг унтраахыг зөвлөж байна.

Хэвийн чийгшил бүхий өрөө тасалгааны суурь гадаргуугийн төрлөөс хамааруулан хөрсжүүлэгчийг сонгох нь

Суурийн төрөл	PLITONIT Гүн нэвтрэх хөрсжүүлэгч	PLITONIT хөрсжүүлэгч 1 Profi	PLITONIT Бэхжүүлэгч хөрсжүүлэгч Profi	PLITONIT Бетонконт акт хөрсжүүлэгч
Бетон, төмөр бетон	—	—	—	+
Цементэн өнгөлөгч шавардлага, тоосго, ЦПС (цемент-элсний зуурмаг), өөрөө тэгшлэгч шал	+	1:5	—	—
Цементэн үс тусгаарлагч	+	1:5	—	—
Нүхтэй суурь (хийт бетон, хөөсөнцөр бетон гэх мэт)	—	—	1:2	—
Чанар муутай (сул), бутардаг болон шохойжсон суурь	—	1:2	1:2	—
Гипсэн хавтан, Шилэн судалтай гипсэн хавтан, Шилэн магнетит хавтан	+	1:5	—	—
Гипсэн өнгөлөгч шавардлага	Гипсэн өнгөлөгч шавардлагаар өнгөлөх (хавтан наах) үед PLITONIT WaterProof Standard эсвэл PLITONIT ГидроЭласт үс тусгаарлагч мастикаар тусгаарлах үе үүсгэхийг зөвлөж байна			

Чийглэг ихтэй өрөө тасалгаа болон нойтон бүсийн суурийг бэлтгэх

Угаалгын өрөөний хана, шал	Суурийн төрлөөс үл хамааран мастикаар 1 үе үс тусгаарлагч хийнэ
Гал тогооны ханын хавтан	PLITONIT WaterProof Standard буюу PLITONIT ГидроЭласт
Шүршүүрийн өрөөний шал, хана	Суурийн төрлөөс үл хамааран PLITONIT WaterProof Standard эсвэл PLITONIT ГидроЭласт мастикаар 2 үе үс тусгаарлагч хийнэ

Зуурмагийн хольц бэлтгэгч

Хуурай хольцыг нийлүүлж холихдоо нийтийн усны хангамжийн усыг ашиглах боломжтой.

Холих харьцаа нь 1 кг хуурай цавууны хольцод 0,19-0,26 литр (1 уут буюу 25 кг-д 4,75 - 6,5 литр) ус шаардагдана.

1	Хуурай хольцыг зуурахад шаардлагатай тасалгааны температуртай усны хэмжээг хэмжиж авна
2	Хуурай хольцыг урьдчилан хэмжсэн хэмжээтэй усанд хийнэ
3	Хуурай хольц болон усыг цахилгаан холигч эсвэл хошуутай цахилгаан ерөм ашиглан нэгэн төрлийн зуурмаг болтол 2-3 минутын турш хутгана***
4	Зуурмагийг 5 минут амраагаад дахин нэг удаа хутгана

*** эргэлтийн хурд 600 эрг/мин-ээс ихгүй байна

Ажил гүйцэтгэх дараалал

1	Бэлтгэсэн зуурмагийг сүүрийн гадаргуу дээр жигд тараан, гөлгөр хусуураар түрхэж ховилтой хусуураар долгион гаргах байдлаар түрхэнэ*
2	Зуурмагийг асгаснаас хойш 30 минутын (ажил гүйцэтгэх хугацаа) дотор өнгөлгөөний хавтанг наах боломжтой байхаар тооцон гүйцэтгэнэ.
3	Хавтанг цавууны зуурмаг дээр байрлуулж, үл ялиг эргүүлэх хөдөлгөөнөөр доош нь дарж наана (600х600 мм-ээс дээш хэмжээтэй хавтанд зориулалтын доргиулагч төхөөрөмж ашиглана)

«Ажил гүйцэтгэх дараалал» бүлгийн нэмэлт өөрчлөлтүүд

Хусуурын шүдний өндрийг хавтангийн хамгийн урт талын хэмжээнээс хамаарч тооцно				
1	Хавтангийн хамгийн урт талын урт	30 см хүртэл	30-аас 60 см хүртэл	60 см-ээс дээш
	Хусуурын ховилын гүн, мм	6-8 мм	10 мм	12 мм
2	Өнгөлгөөний хавтанг байрлуулах үед хавтангийн ар талын овгор зузаан нь 2 мм хэмжээ нь 30х30 см-аас том хэмжээтэй тохиолдолд хавтан, гадаргуу хоёрын хооронд хоосон зай гаргахгүй байх, барьцалдахыг бат бэх болгох зорилгоор гадаргуу болон хавтангийн ар талд зуурмагаа хосолсон аргаар түрхэж хэрэглэнэ. Цавууг дээр дурдсанчлан суурь дээр хэрэглэнэ. Хавтангийн ар талд цавууг эхлээд 2-4 мм-ийн шүдний өндөртэй шүдтэй хусуураар түрхэж, дараа нь тэгш (гөлгөр) хусуураар цавууны үеийг хавтангийн бүх талбайд жигд тэгшлэн тараана.			
3	Хавтанг заадас (оёдол) гаргаж наах бөгөөд ХТС (хавтан тэгшлэгч систем), тах, чатган хэрээс зэрэг зориулалтын багаж хэрэгслийн тусламжтайгаар тэгшилнэ.			
4	Нэвт салхи, өндөр температур болон гадаргуугийн ус сорох чадвар өндөр байх нь цавууны ил задгай байх хугацаа болон засаж янзлах хугацааг богиносгодог			

Ажлын нөхцөл

Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших 3 хоногт агаарын температур, сүүрийн болон хавтангийн температур +5 °C-аас +30 °C хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад зуурмагийн температур +10°C-аас +30°C хүртэл байх нь зохимжтой. Гадаргууг гаднах ажлын гүйцэтгэлийн үед хур тунадаснаас хамгаалах шаардлагатай.

Анхааруулга

Хавтанг гадаргуу дээр байрлуулснаас хойш 24 цагаас багагүй хугацааны дараа дээгүүр нь алхах, чигжээс хийж болно. Шалны халаалтыг ажиллуулахыг ус чийгт тэсвэртэй хавтан дээр хийсэн тохиолдолд хавтанг нааснаас хойш 3-аас багагүй хоногийн дараа энэ үйлдлийг хийхийг зөвшөөрнө.

Дээр заагдсан хугацаа нь орчны температур (20±2)°C, агаарын харьцангуй чийгшил (60±10)%-д үйлчлэх бөгөөд бусад температур-чийглэгийн нөхцөлтэй үед энэ хугацаа нь хэлбэлзэж болно. Ажлыг гүйцэтгэхэд барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилга дагаж мөрдөх ёстой. Хавтанг тавихаас өмнө дэвтээж болохгүй, хавтангийн арын хэсгийг тоос, шорооноос цэвэрлэх хэрэгтэй. Ажил гүйцэтгэх явцад зуурмагийг үе үе хольж байх ёстой. Үйлдвэрлэсэн байршил болон бусад хүчин зүйлээс хамаарч зуурмагийн өнгө нь багц (цуврал) бүрт өөр өөр байх боломжтой. Зуурмагийн өнгө нь бүтээгдэхүүний заасан техникийн үзүүлэлтүүд болон чанарт нөлөөлөхгүй.

Аюулгүй ажиллагаа

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна

Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй

Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийгээрэй. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГА!

Орц, найрлага

Портландцемент, кварцын элс, холбогдох нэмэлт бүтээгдэхүүнүүд.

Тээвэрлэлт ба хадгалалт

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хаалттай хуурай өрөөнд хадгална. Үйлдвэрлэгчийн саванд хадгалах хугацаа нь тээвэрлэх, хадгалах нөхцөл зөрчигдөөгүй үед үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл, энэ зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ Р 56387 стандарт С2 Т ангилал болон ТУ 23.64.10-299-51552155-2025 техникийн нөхцөлийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулж байна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ 8.579-2002 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн. (Аэфф<370 Бк/кг байх НРБ-99/2009 ОХУ-ын Цацрагийн аюулгүй байдлын стандарт, СанПин2.6.1.2523-09 ариун цэврийн дүрэм, журамд нийцсэн).

Зарцуулалт

Ашиглаж буй хусуурын шүдний өндрөөс хамаарсан материалын зарцуулалт				
Хавтангийн хамгийн урт талын урт	20 мм хүртэл	20-иос 30 см хүртэл	30-аас 60 см хүртэл	60 см-ээс дээш
Хусуурын ховилын гүн, мм	6	8	10	12
1 м ² -д зарцуулагдах зуурмагийн хэмжээ, кг	3,98	5,3	6,63	7,95
25 кг цавуу ашиглахад наах хавтангийн талбай, м ²	6,3	4,7	3,8	3,1

ХЭРЭГЛЭГЧИЙН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

8 (800) 555 - 71 - 67

www.plitonit.ru

e-mail: info@mc-bauchemie.ru